



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/24

Баян-Адарга

Г 7
Төрийн албан хаагчдын зөвлөгөөн
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61, 62 дугаар зүйл, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 8 дугаар хуралдааны 2026 оны Төсөв батлах тухай 8/6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Адарга сумын Төрийн алба хаагчдын зөвлөгөөн зохион байгуулах, бэлтгэл ажил хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: С.Пүрэвцэрэн (Төсвийн ерөнхий Нягтлан бодогч)

Г.Үүрийнтуяа (Хууль, эрх зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)

Г.Гимаа (Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн)

О.Жаргалцэцэг (Татварын байцаагч)

Д.Өлзийсайхан (Хүүхэд, гэр бүлийн Нийгмийн ажилтан)

Б.Баярцэцэг (Тархвар зүйч)

Б.Алтаргана (ХЭХАХМ мэргэжилтэн)

Н.Цолмонбаяр (Адарга багийн Засаг дарга)

2. Төрийн алба хаагчдын зөвлөгөөн зохион байгуулах, бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж, ажлын үр дүнг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр тайлагнахыг Ажлын хэсгийн ахлагч (С.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргийг гүйцэтгэж, хамтран ажиллахыг төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт даалгасугай.

4. Зөвлөгөөнд шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардлаас зарцуулахыг сумын Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Б.Агиймаа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  ОЛХАГВАДОРЖ

